

Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг улсын бүртгэлд бүртгэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг улсын бүртгэлд бүртгэж савны ашиглалтын үеийн хэвийн найдвартай байдлыг хангах, савны паспорт ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална. /өөрчлөн найруулсан/

1.2. Энэхүү журам нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Газрын тосны тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудад үндэслэж, тэдгээрт нийцсэн байна. /өөрчлөн найруулсан/

1.3. Шинээр баригдсан болон угсарч, суурилуулсан савыг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөхөөс өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Сав тус бүр улсын бүртгэлтэй байна. /өөрчлөн найруулсан/

1.4. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг ашиглалтад ороход савны ашиглалтын нөөцөд эрх бүхий байгууллагаар сорилт хийлгэж баталгаажуулсан байна. Шинээр үйлдвэрлэсэн савны хувьд үйлдвэрээс дагалдсан бичиг баримт. /шинээр нэмж оруулсан/

1.5. Энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэх баримт бичиг нь эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан байна. /шинээр нэмж оруулсан/

1.6. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг бүртгэх, улсын бүртгэлийн дугаарт Монгол Улсын бүсчлэлийн код, бүтээгдэхүүн хадгалж буй байгууламжийн төрлийн нэршлийн товчлол, савны технологийн схемийн дугаар, объектын дугаар хамаарна. /шинээр нэмж оруулсан/

Бүтээгдэхүүн хадгалж буй байгууламжийн төрлийн нэршлийн товчлол: Суурин шатахуун түгээх станц /СШТС/, зөөврийн шатахуун түгээх станц /ЗШТС/, байгууллагын хэрэгцээний шатахуун түгээх станц /БХШТС/, газрын тосны бүтээгдэхүүний агуулах /ГТБА/, түүхий тосны агуулах /ТТА/, мазут хадгалах агуулах /МХА/, битум хадгалах агуулах /БХА/. /шинээр нэмж оруулсан/

1.7. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах сав бүртгүүлэх хүсэлтийг журмын 3 дугаар зүйлд заасан бичиг баримтын хамт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажлын 10 хоногт улсын бүртгэлд бүртгэнэ. /шинээр нэмж оруулсан/

1.8. Хэрэв шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 1.7-д заасан хугацааг ажлын 5 хоногоор сунгаж болно. /шинээр нэмж оруулсан/

1.9. Бүтээгдэхүүн хадгалах саванд технологийн бүрэн шинэчлэл хийсэн нөхцөлд савыг шинээр улсын бүртгэлд бүртгүүлнэ. /шинээр нэмж оруулсан/

1.10. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулан

Хоёр. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалтын савыг улсын бүртгэлд бүртгэх хамрах хүрээ /шинээр нэмж оруулсан/

2.1. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний 10м³ болон түүнээс дээш багтаамжтай, суурин болон зөөврийн, байгууллагын хэрэгцээний бүтээгдэхүүн хадгалах сав хамаарна. /бүх төрлийн шатахуун болон түүхий тос, битум, мазут/ /шинээр нэмж оруулсан/

2.2. Зөөврийн сав нь уул уурхай, зам засвар, газар тариалан зэрэг цаг үеийн үйл ажиллагааны үед 3 хүртэл сарын хугацаагаар ашиглах сав хамаарна. /шинээр нэмж оруулсан/

Гурав. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх бичиг баримт /шинээр нэмж оруулсан/

3.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, /шинээр нэмж оруулсан/

3.2. Архитектур төлөвлөлтийн даалгавар, мэргэжлийн байгууллагаар боловсруулж, магадлал хийлгэсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын нэгтгэсэн дүгнэлтийн хамт, /шинээр нэмж оруулсан/

3.3. Зураг төслийг боловсруулсан этгээдийн тусгай зөвшөөрөл, /шинээр нэмж оруулсан/

3.4. Савыг үйлдвэрлэсэн болон угсарч суурилуулсан этгээдийн тусгай зөвшөөрөл. /шинээр нэмж оруулсан/

3.5. Сав тоног төхөөрөмжийн угсралтын ил, далд ажлын акт, даралтаар шалгасан болон битүүмж шалгасан тухай акт, гагнуурын ажлын чанар акт формулярын баримт материал. /шинээр нэмж оруулсан/

3.6. Савны ашиглалтын нөөц тогтоосон дүгнэлт, шинээр үйлдвэрлэсэн савны хувьд үйлдвэрээс дагалдсан паспорт. /шинээр нэмж оруулсан/

Хоёр. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг өмчлөгч, эзэмшигчдэд тавигдах шаардлага

2.1. Савыг ашиглагч, өмчлөгч нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг улсын бүртгэлд бүртгүүлэх мэдээллийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим системээс авна. /өөрчлөн найруулсан/

2.2. Журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу өөрийн эзэмшилд байгаа газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалтын савны мэдээллийг сав тус бүр дээр үнэн зөв бөглөсөн байна. /өөрчлөн найруулсан/

2.3. Савны ашиглалтын үеийн шилжилт хөдөлгөөн болон хийгдсэн өөрчлөлтийн талаарх мэдээллүүдийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэж сав ашиглалтын паспортад тэмдэглэл хийлгэсэн байна. Тэмдэглэл хийлгэхгүйгээр өөрчлөлт оруулсан тохиолдолд тухайн савны паспортыг хүчингүй болсонд тооцно. /өөрчлөн найруулсан/

2.4. Сав ашиглалтын паспортыг үрэгдүүлсэн тохиолдолд бүртгүүлэх мэдээллийг дахин бүрдүүлэн, нөхөн авах хүсэлтээ газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ. /өөрчлөн найруулсан/

2.5. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савны ашиглалтын паспортын “Улсын бүртгэлийн дугаар”-ыг сав тус бүр дээр тэмдэглэж, тэмдэглэгээ хийнэ. /өөрчлөн найруулсан/

2.6. Савыг өмчлөгч, эзэмшигч өөрчлөгдөх болон ашиглахаа больсон тохиолдолд савны эзэмшигчид шилжилт хийлгэх, улсын бүртгэлээс хасуулж, паспортыг хураалгасан байна. Дахин ашиглахаа больсон сав, тоног төхөөрөмжийг зайлуулах, үлдэгдлийг цэвэрлэх, хөрсийг хэвийн байдалд оруулан хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй болгох, бохирдсон болон эвдэрч гэмтсэн газрын хөрсийг нөхөн сэргээсэн талаар эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулна. /өөрчлөн найруулсан/

Гурав. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавигдах шаардлага

3.1. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг бүртгэж улсын нэгдсэн бүртгэлд хамруулах ажлыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

3.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах зориулалтаар суурилуулагдан ашиглагдаж байгаа бүх савны судалгаа хийж, савны ашиглалтын паспортыг үндэслэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

3.3. Савны ашиглалтын паспортын маягт, савыг улсын бүртгэлд бүртгэх журмыг өөрийн байгууллагын цахим хуудаст байрлуулна.

3.4. Савыг ашиглагч, өмчлөгчөөс ирүүлсэн баримт бичиг, бөглөж ирүүлсэн ашиглалтын паспортыг үндэслэн ажлын 10 хоногийн дотор бүртгэл хийж, улсын бүртгэлийн дугаар олгон бүртгэж, паспорт олгоно. Хэрэв шаардлагатай гэж үзвэл энэхүү хугацааг ажлын 5 хүртэл хоногоор сунгаж болно. /өөрчлөн найруулсан/

3.5. Эзэмшигч өөрчлөгдсөн болон ашиглахаа больсон савны паспортыг хураах, шилжилт хөдөлгөөн хийх, улсын бүртгэлээс хассан талаарх холбогдох мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад хуанлийн 14 хоногийн дотор хүргүүлнэ. /өөрчлөн найруулсан/

3.6. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах савыг бүртгэх үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын болон холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг татан оролцуулах, савыг бүртгэхэд тавигдах шаардлага, нөхцөлийн талаар дүгнэлт гаргуулах эрхтэй.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллагад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Журмын хэрэгжилтэд газрын тосны асуудал эрхэлсэн байгууллага хяналт тавина. /өөрчлөн найруулсан/

Уул уурхай, хүнд үйлдвэрийн
сайдын 20... оны .. дүгээр/дугаар
сарын ...-ний/ны өдрийнтоот
тушаалын хоёрдугаар хавсралт

**ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
ХАДГАЛАХ САВНЫ АШИГЛАЛТЫН БҮРТГЭЛ, ПАСПОРТ**

Улсын бүртгэлийн дугаар:

Паспорт нээсэн огноо:

Савны хамрах хүрээ:

Эзэмшигч компанийн нэр:

Байршил:

Савны технологийн схем дэх дугаар:

Багтаамж/м3/

Хадгалах бүтээгдэхүүний төрөл:

Шилжилт хөдөлгөөн хийсэн тэмдэглэл:

*Савыг өөр эзэмшигчид шилжүүлэх тохиолдолд энэ
паспортыг заавал хамт дагалдуулна.*

САВНЫ ТӨЛӨВЛӨЛТ ХИЙЖ, УГСАРЧ, СУУРИЛУУЛСАН ТОДОРХОЙЛОЛТ		
Д/д	Үзүүлэлтүүдийн нэр	Үзүүлэлтүүдийн тоо хэмжээ, утга /Тайлбар/
1.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл;	
2.	Архитектур төлөвлөлтийн даалгаварын огноо, дугаар;	
3.	Зураг төсөлд магадлал хийсэн нэгтгэсэн дүгнэлт;	
4.	Зураг төслийг боловсруулсан хуулийн этгээд, зураг зохиогчийн нэр, тусгай зөвшөөрөл дугаар, хүчинтэй хугацаа;	
5.	Савыг угсарсан зураг төслийн дугаар, шифр;	
6.	Зургийг үйлдсэн он сар өдөр;	
7.	Угсралт гүйцэтгэсэн байгууллагын нэр, савыг угсарсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, хүчинтэй хугацаа;	
8.	Савны марк, эзэлхүүн м ³	РГС-50 гэх мэтээр савны маркийг бичнэ.
9.	Савны төрөл;	Хэвтээ буюу босоо цилиндр /бөмбөлөг/ хэлбэртэй гэж бичнэ
10.	Савыг хийсэн материалын тодорхойлолт;	Савыг хийсэн материалын хатуулаг, найрлага, бөх батын хязгаар гэх мэтийн уг материалд үйлдвэрлэгчээс дагалдуулсан баримт бичгүүдээс иш татан түүний шинж чанаруудыг тодорхой бичнэ.
11.	Савыг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрийн нэр, тусгай зөвшөөрөл, бэлтгэн нийлүүлэгчийн нэр;	Савыг БНХАУ, ОХУ-ын Омскийн үйлдвэрт үйлдвэрлэсэн г.м эсхүл-ийн харьяа ... агуулахаас худалдан /шилжүүлэн/ авсан г.м.
12.	Савыг үйлдвэрлэсэн он. сар;	
13.	Савны ажлын даралт, вакуум, Мпа;	Ажлын даралт , сийрэгжилтийн зөвшөөрөгдөх хэмжээг Мпа -аар бичнэ.
14.	Савны хүндийн жин, угсрагдсан тоног төхөөрөмжийн хамт, кг;	Савны суурин дээр үйлчлэх түүний нийт хүндийн жинг бичнэ.
15.	Савыг гагнасан электродын марк;	Савыг угсрах үед хэрэглэсэн гагнуурын электродын марк, шинж чанар, төрлийг бичнэ.
16.	Савыг угсрах орчны дээд, доод температур;	Савыг орчны ямар температурт угсрах ёстойг үйлдвэрээс өгсөн паспортын дагуу бичнэ.
17.	Савны ёроол, дээвэр, ханын хийц;	Савны ёроол: Давхар ёроолтой, дан ёроолтой, тэдгээрийн гангийн зузааныг бичнэ. Савны дээвэр: Конус, эллипс хэлбэрийн байнгын дээвэртэй, понтонтой, хөвөгч дээвэртэй тэдгээрийн гангийн зузаан г.м Савны хана: Давхар ханатай, дан ханатай, тэдгээрийн бүс бүрийн гангийн зузаан г.м
18.	Савыг угсарсны дараах геометрийн хэмжээснүүд, /мм/;	Савны өндөр, диаметр, хананы өндөр, хананы, ёроолын, дээврийн зузаан болон бусад хэмжээсүүдийг тодорхой бичнэ.
19.	Савыг угсарч суурилуулсан улирал, орчны агаарын дундаж температур)	Сав угсрах ажлыг эхэлсэн болон барьж дууссан огноо, орчны температурыг тодорхой бичнэ.
20.	Савны суурийн ажлыг хийсэн арга, технологи;	Сав суурилуулсан далд ажлын үеийн бүх үе, шат бичнэ.
21.	Савны дотор гадна талыг зэврэлтээс хамгаалсан түрхлэг хийсэн арга,	Савыг зэврэлтээс хамгаалах ямар аргаар хамгаалсан талаар тодорхой бичнэ. Битум, хуванцар, полимер гэх

		мэт ямар төрлийн бүрхүүлээр бүрсэн, эсвэл цагаан, хөнгөн цагааны нунтаг зэрэг будгаар будсан, катодын арга г.м.
22.	Савны битүүмжлэл, гагнуурын оёдол шалгасан арга, эзэн; /савны гагнаасыг шалгасан болон савны битүүмжлэлийг шалгасан арга, эзэн/	
23.	Савны хийцийн даац, бөх батыг шалгасан арга, эзэн;	
24.	Ямар төрлийн бүтээгдэхүүн хадгалах зориулалттай технологийн угсралттай;	Тухайн саванд түүхий тос, бүх төрлийн шатахуун, мазут г.м ямар төрлийн бүтээгдэхүүн хадгалагдах, уг бүтээгдэхүүний нягт, хувийн жин зэврүүлэх үйлчлэл, дөл авалцах температур хордуулах үйлчлэл зэргийг тодорхойлж бичнэ.
25.	Худалдан авсан тухай тэмдэглэл;	
26.	Савны онцгой тодотгол;	Галын хамгаалалттай, давхар ханатай г.м дэлхийд нэртэй байгууллагын туршилтаар тогтоогдсон г.м.

Хүснэгт 2а

БҮХ ТӨРЛИЙН ШАТАХУУН ХАДГАЛАХ САВАНД УГСРАГДСАН ТОНОГЛОЛ, ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ, ТЭДГЭЭРИЙН АШИГЛАЛТЫН БАЙДАЛ							
№	Савны тоноглолын зориулалт	Тоноглол, хэмжих хэрэгслийн нэр, марк,	Техникийн үндсэн үзүүлэлт	Үйлдвэрлэсэн газар, (Улс, үйлдвэрийн нэр) он сар өдөр	Тоо хэмжээ	Угсарсан он сар өдөр. Угсарсан хүний нэр, албан тушаал, гарын үсэг	Сольсон засварласан он, сар, өдөр. Сольсон, засварласан хүний нэр, албан тушаал, гарын үсэг
1.	Түвшин хэмжих						
2.	Хөрсний бохирдлыг хянах						
3.	Гоожилт шүүрэлт хянах						
4.	Савны дүүргэлт хязгаарлах						
5.	Дээж авах төхөөрөмж						
6.	Хамгаалах клапан						
7.	Амьсгалах клапан						
8.	Цэвэрлэгээний люк						
9.	Гэрлийн люк						
10.	Хөөс өгөх төхөөрөмж						
11.	Ус өгөх төхөөрөмж						
12.	Аянга зайлуулах, газардуулах төхөөрөмж						

**Түүхий тос хадгалах саванд угсрагдсан тоноглол, хэмжих хэрэгсэл,
тэдгээрийн ашиглалтын байдал**

Хүснэгт 2б

№	Савны тоноглолын зориулалт	Тоноглол, хэмжих хэрэгслийн нэр,	Техникийн үндсэн үзүүлэлт	Үйлдвэрлэсэн газар, (Улс, үйлдвэрийн нэр)	Тоо хэмжээ	Угсарсан он сар өдөр. Угсарсан хүний нэр, албан тушаал гавын	Сольсон засварласан он, сар, өдөр. Сольсон, засварласан
1	Цэвэрлэгээний люк						
2	Гэрэлтүүлгийн люк						
3	Амьсгалах клапан						
4	Гал унтраах хөөсний систем						
5	Хэмжилтийн хэсгийн таг						
6	Ус зайлуулах хоолой						
7	Цэвэршүүлсэн тосны орлогын хоолой						
8	Цэвэршүүлсэн тосны зарлагын хоолой						
9	Тунасан усны гаралт						
10	Түүхий тосыг хэвийн температурт барих усны шугам /Түүхийн тосны t ийг хэвийн барьжэ буй халаах хэрэгслийн техникийн үзүүлэлт/						
11	Усны буцах урсгал /Гарах усны хоолойн диаметрийн хэмжээ/						
12	Тос-усны зааг болон шингэний түвшинг харуулах суваг						
13	Шингэний түвшингийн аюулыг урьдчилан мэдээлэх люк						
14	Шингэний температурыг хэмжих люк						
15	Хийн температурыг хэмжих люк						
16	Биметал температур хэмжигчийн оролт /саван доторх түүхий тосны мэдээлэгч, хянагч/						

**Мазут, битум хадгалах саванд угсрагдсан тоноглол, хэмжих хэрэгсэл,
тэдгээрийн ашиглалтын байдал**

№	Савны тоноглолын зориулалт	Тоноглол, хэмжих хэрэгслийн нэр, марк, тип	Техникийн үндсэн үзүүлэлт	Хадгалах хэм °С	Үйлдвэрлэсэн газар, (Улс, үйлдвэрийн нэр) он сар өдөр	Тоо хэмжээ	Угсарсан он сар өдөр. Угсарсан хүний нэр, албан тушаал, гарын үсэг	Сольсон засварласан он, сар, өдөр. Сольсон, засварласан хүний нэр, албан тушаал, гарын үсэг
1	Хадгалах савны хэмийн горимыг тохируулах цахилгаан халаагуур,							
2	Хадгалах савны дулаан тусгаарлагч /чанарын шаардлага хангасан савны дулаан тусгаарлагч/							
3	Дамжуулах шугам хоолойн дулаан тусгаарлагч /чанарын шаардлага хангасан савны дулаан тусгаарлагч/							
4	Цэвэрлэгээний люк							
5	Гэрэлтүүлгийн люк							
6	Амьсгалах клапан							
7	Тосон халаагуур							
8	Тосон халаагуурын хий авагч							
9	Дулаан мэдрэгч,							
10	Дулаан тохируулагч							
11	Ослын сав							

Тайлбар: Тухайн саванд ямар зориулалтаар, ямар тоноглол, хэмжүүр хэмжих хэрэгсэл угсрагдсаныг хүснэгтэд заасан асуултын дагуу тодорхой дэлгэрэнгүй хариулж бичих бөгөөд тоноглол, хэмжүүр хэмжих хэрэгсэлд засвар хийсэн болон сольсон тухай бүрд тухай тэмдэглэл хийж, тодорхой албан тушаалтан баталгаажуулсан байна.

АШИГЛАЛТЫН ЯВЦАД САВНЫ БИТҮҮМЖЛЭЛ ШАЛГАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ				
Д/д	Он сар өдөр	Битүүмжлэлийн шалгалтын тухай тэмдэглэл	Гүйцэтгэсэн байгууллага, хариуцсан хүний нэр, албан тушаал, гарын үсэг	Улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын тэмдэглэл

Тайлбар: Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг 5 жил тутамд 1-ээс доошгүй удаа битүүмжлэл шалгасан акт үйлдэж, паспортад тэмдэглэл хийсэн байна. Савны үндсэн эд анги болон тоноглолуудад үйлдвэрээс тогтоосон бусад техникийн баримт бичигт заагдсан техникийн үйлчилгээ, урсгал, дунд, их засварын талаар тодорхой бичнэ.

Оношилгооны дүгнэлт				
Улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын тэмдэглэл				

Тайлбар: Савны ашиглалтын нөөцийг тогтоосон талаар тэмдэглэлийг гүйцэтгэсэн байгууллагаар нь асуултын дагуу тэмдэглэл хийлгэж, дэлгэрэнгүй тайланг хавсаргана.

Энд: /*/ - Савны ашиглалтын нөөц тогтоосон дэлгэрэнгүй тайланг хавсаргана.

- Савны хазайлтыг болон шалны бамбалзуурыг /хлопуныг/ хэмжсэн талаарх мэдээллийг тусад нь хавсралтаар хийнэ.

Хүснэгт 7

САВ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ			
Ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Савыг суурилуулсан газрын байршил	Шилжүүлж байрлуулсан буюу эзэмшигч өөрчлөгдсөн огноо	Улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын тэмдэглэл

Тайлбар: Савны шилжилт хөдөлгөөний талаар тодорхой тэмдэглэл хийнэ.

САВНЫ БҮРТГЭЛ:

Паспорт хуудастай, хавсрагдах бусад баримт бичиг хуудастай болно.

Бүртгэсэн:

/бүртгэсэн хүний албан тушаал/

Савыг -д бүртгэв.

/тэмдэг/

Тусгай нөхцөл, шаардлага:

- Улсын бүртгэлийн дугаарыг сав тус бүр дээр тэмдэглэсэн байна.
- Ашиглалтын явцад савны битүүмжлэл шалгасан, ашиглалтын явцад савны үндсэн эд анги, тоноглолыг засварласан, савны цэвэрлэгээ хийсэн талаар сав ашиглалтын явцад паспортод тэмдэглэл хийсэн байна.
- Савны цэвэрлэгээ, савны ашиглалтын нөөцийг тогтоосон акт үйлдсэн тухай бүрд паспортод тэмдэглэл хийсэн байна.
- Савны ашиглалтын нөөцөд эрх бүхий байгууллагаар сорилт хийлгэсэн дүгнэлт хавсаргах,

- Савны ашиглалтын үеийн шилжилт хөдөлгөөн, сав шинэчлэн засварласан өөрчлөлтийн талаарх мэдээллүүдийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэж, паспортод тэмдэглэл хийлгэсэн байна.
- Савны паспортыг үрэгдүүлсэн тохиолдолд дахин материал бүрдүүлэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- Савыг өмчлөгч, эзэмшигч нь дахин ашиглахаа больсон сав, тоног төхөөрөмжийг зайлуулах, газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдлийг цэвэрлэх, газрыг тэгшилж хөрсийг хэвийн байдалд оруулан хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй болгох, бохирдсон болон эвдэрч гэмтсэн газрын хөрсийг нөхөн сэргээж ургамалжуулна.

Нэмэлт тэмдэглэл:

Тэмдэглэл хийсэн.....

/бүртгэсэн хүний албан тушаал/

.....
/ Бүртгэлийн дугаар /

.....
/ Нэр гарын үсэг /

Тусгай нөхцөл, шаардлага:

Тэмдэглэл хийсэн.....

/бүртгэсэн хүний албан тушаал/

.....
/ Бүртгэлийн дугаар /

.....
/ Нэр гарын үсэг /

Тусгай нөхцөл, шаардлага:

Тэмдэглэл хийсэн.....

/бүртгэсэн хүний албан тушаал/

.....
/ Бүртгэлийн дугаар /

.....
/ Нэр гарын үсэг /

Тусгай нөхцөл, шаардлага: